



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 10 өдөр

Дугаар АА/С

Булган сум

**Зөвлөн туслах ажлын хэсэг
томилох тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 17.1.5 дахь заалт, Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 5633:2023 стандартыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгуулсугай.

2.Зөвлөн туслах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар хавсралтаар баталсугай.


3.Ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр ханган эргэн мэдээлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Одончимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/Н/С дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлын
хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: Г.Одончимэг (Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)
- Гишүүд: Б.Чулуунцэцэг (Онцгой байдлын газрын
Урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ
хариуцсан мэргэжилтэн, Дэслэгч)
- Ш.Өлзийхутаг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнс,
хоол үйлдвэрлэл, худалдаа хариуцсан ахлах
мэргэжилтэн)
- Д.Лхагвадолгор (Эрүүл мэндийн газрын Эх
хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн)
- Нарийн бичгийн дарга: С.Оюунзаяа (Хүүхэд, гэр бүлийн хөгжил,
хамгааллын газрын Хамгааллын ахлах
мэргэжилтэн)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/МНС дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗӨВЛӨН
ТУСЛАХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Зорилго: Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Хүүхдийн зуслангуудыг бүртгэлжүүлэх, үйл ажиллагаанд зөвлөн туслах, MNS 5633:2023 стандартын хэрэгжилтийг хангах, хүүхдийн эрсдэж болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулах.

Хамрах хүрээ: Булган аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлдэг Хангал сумын “Найрамдлын эрдэс”, “Энэрэл”, Хялганат тосгоны “Янзага”, Ерөнхий боловсролын сургуулийн дэргэдэх “Хөдөлмөр зуслан”, Бугат сумын “Эдү тур”, “Жаргалант” зэрэг зуслан.

Хугацаа: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл.

Зохион байгуулагчид: Аймгийн засаг даргын тамгын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар.

Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл:

- Зуслангийн барилга байгууламжийн ерөнхий шаардлага, галын аюулгүй байдал.
- Хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог хангасан, хүүхдэд ээлтэй хөгжлийн орчин бүрдүүлсэн байх.
- Эрүүл хоол хүнс, хоолны газрын үндсэн шаардлага хангах.
- Хүүхдийн зусланд ажиллах хүний нөөцөд тавих ерөнхий шаардлага хангах.

Хүлээгдэж буй үр дүн:

- Гал гарч болзошгүй болон, ил тогны утас, монтаж, шалбарсан тогтой утас зэргийг шалгаж, эрсдэлт нөхцөлийг бууруулж, хяналт шалгалт хийгдсэн байна.
- Хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, эвдэрч муудсан байшин, барилгыг засаж, сэлбэх, засварлагдсан байна.
- Хүүхдийн насны онцлогт тохирсон стандартын шаардлага хангасан хоол хүнсний жишиг цэстэй болсон байна.
- Хүүхэд хөгжлийн чиглэлээр багшлах арга зүйч, багш нарын ур чадвар, ёс зүй сайжирсан байна.

Холбоо барих: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын ахлах мэргэжилтэн С.Оюунзаяатай холбогдох (88143456)

--o00o--